



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 10 сарын 06 өдөр

Дугаар 14/2017

Мандалговь

“Бага олимп-2017” зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.2, 10.1.5, 10.1.7, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, төлөвлөгөөний 3.3.3 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2017 оны 14 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын нэрэмжит “Бага олимп-2017”-г энэ оны 10 сарын 19-22-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

Хоёр. “Бага олимп-2017”-г зохион байгуулах зардлыг хавсралтаар баталсугай.

Гурав. “Бага олимп-2017”-д шаардагдах 10000000 /Арван сая/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн ЗДТГ-ын дарга /Ц.Эрдэнэсүрэн/, нягтлан бодогч /Ц.Даваа/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200927

